



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/14/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	10
3.5.2 Авлага	11
3.5.3 Урьдчилгаа	12
3.5.4 Бараа материал	12
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	13
3.5.6 Үндсэн хөрөнгө	13
3.5.7 Өр төлбөр	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	22
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	22
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/243
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Аргалант сум нь Монгол Улсын Засгийн газраас “Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн” өрнүүлж, цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралыг даван туулах, баялаг бүтээгчдээ дэмжих эрхэм зорилгыг хэрэгжүүлэхээр “Ногоон хөгжил баялаг бүтээгчдийг” дэмжих урианы жил болгон зарлаж ажилласан байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Баялаг бүтээгчдийг дэмжих” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 18 зорилтын хүрээнд 173 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 81.66%-тай биелүүлж, “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторов мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Энэ нь Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны 10/84 тоот албан бичгийн дагуу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн 2,818,105.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 56,138.9 мянган төгрөгийн бараа материалыг, мөн давхар бүртгэгдсэн байсан Аргалант

G/Arkhir/Alban bichig 2023/ A4

19020462

илч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 703,095.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 13,396.1 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		871,889.2	903,223.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	269,211.0	462,776.3
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	323,384.2	326,584.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	279,294.0	113,862.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,053,024.6	2,537,847.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,053,024.6	2,537,847.6
39200	Биет хөрөнгө		4,325,053.7	1,884,658.9
39300	Биет бус хөрөнгө	13	727,970.9	653,188.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,924,913.8	3,441,071.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		17,836.4	5,149.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	17,836.4	5,149.6
41300	Өглөг	17а, 17б	17,836.4	5,149.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,907,077.4	3,435,921.6
51	Засгийн газрын хувь оролцоо		5,907,077.4	3,435,921.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,352,620.6	1,385,745.2
51200	Хуримтлагдсан үр дүн		1,522,735.9	1,907,704.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,271,666.6	142,471.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		5,924,913.8	3,441,071.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,389,570.0	1,277,343.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		123,496.2	404,285.7
110	Орлогын албан татвар		69,877.4	257,721.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		69,877.4	273,057.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-15,336.5
113	Хөрөнгийн албан татвар		8,024.4	86,889.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		45,594.4	59,675.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	725,940.2	350,018.8
120	Нийтлэг татварын бус орлого		725,940.2	350,018.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,540,133.6	523,039.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,012,846.2	935,440.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,008,781.0	881,373.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,189,046.3	875,978.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,127,797.1	250,572.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		159,435.3	32,244.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		357,201.6	270,515.6
2104	Хангамж, бараа материалын зардал		42,159.0	27,641.1
2105	Нормативт зардал		142,836.6	75,317.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		6,112.0	5,350.0
2107	Томилолт, зочны зардал		1,879.2	3,118.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,093.5	23,401.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		347,532.0	187,818.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		819,734.8	5,394.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		4,065.2	54,066.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		376,723.8	341,903.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		308.0	1,809,959.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		376,415.8	-1,468,055.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,073,190.3	1,185,235.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	123,496.2	404,285.7
110	Орлогын албан татвар	69,877.4	257,721.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	69,877.4	273,057.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,336.5
113	Хөрөнгийн албан татвар	8,024.4	86,889.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,594.4	59,675.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,588.4	4,611.8
1181	Газрын төлбөр	29,573.6	53,556.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,432.4	1,507.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	409,560.4	257,911.0
120	Нийтлэг татварын бус орлого	409,560.4	257,911.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,540,133.6	523,039.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,789,186.5	755,485.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,789,186.5	755,485.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,975,822.0	737,423.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,128,134.9	251,879.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,297.4	28,970.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	356,396.1	270,459.4
2104	Хангамж, бараа материалын зардал	36,861.8	12,503.6
2105	Нормативт зардал	131,426.6	90,310.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,902.9	5,350.0
2107	Томилолт, зочны зардал	1,879.2	3,218.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,280.2	27,956.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,642.8	46,775.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	813,364.5	18,062.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	284,003.8	429,750.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	70,184.6	236,084.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,184.6	236,084.7
2200	Дотоод эх үүсвэрээр	70,184.6	236,084.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-70,184.6	-236,084.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-89,308.0	-100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	89,308.0	100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	124,511.1	193,565.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	144,699.9	269,211.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	269,211.0	462,776.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,530,661.6	5,530,661.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,530,661.6	5,530,661.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	376,415.8	376,415.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,907,077.4	5,907,077.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,907,077.4	5,907,077.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,003,100.1	-1,003,100.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,903,977.3	4,903,977.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-1,468,055.7	-1,468,055.7
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,435,921.6	3,435,921.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,065,069.3	861,914.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	669,831.4	625,729.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	667,831.4	623,748.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,478.0	251,879.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,562.4	28,970.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	274,066.5	270,459.4
2104	Хангамж, бараа материалын зардал	11,508.7	11,426.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,350.0	5,350.0
2107	Томилолт, зочны зардал	3,218.5	3,218.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,689.3	27,239.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,958.0	25,205.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000.0	1,981.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.0	1,981.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	272,237.9	236,084.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	123,000.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,065,069.3	933,888.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	94,807.1	94,807.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	686,464.4	751,986.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	283,797.8	87,094.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.0	124,195.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.0	184,557.4
61	Байгууллагын тоо	2	2
62	Ажиллагсадын тоо	24	24
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,567.1	30,033.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,567.1	30,033.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,589.7	16,843.4
2104	Хангамж, бараа материалын зардал	130.2	1,026.3
2105	Нормативт зардал	240.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	477.7	300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,741.9	15,517.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,977.3	13,190.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,519.9	4,380.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,457.4	8,810.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	167,656.8	29,944.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	167,656.8	29,944.2
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	89.7	-89.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	89.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	89.7	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Баялаг бүтээгчдийг дэмжих” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 18 зорилтын хүрээнд 173 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 81.66%-тай биелүүлж, “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын 2 төсөвт байгууллагад удирдах 7, гүйцэтгэх 10, үйлчилгээний 3, гэрээт 4, нийт 24 орон тоотой баталж, гүйцэтгэлээр 24 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аргалант сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2022 онд нийт 12 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан. Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Аргалант сумын ИТХ, Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, соёлын төв, зэрэг байгууллагууд эрсдэл багатай, Засаг даргын тамгын газар дунд эрсдэлтэй, эрүүл мэндийн төв эрсдэл өндөртэй шалгагдаж цаашид санхүү тасгийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах албан шаардлага зөвлөмж өгсөн үүрэг даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө гарган хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Аргалант сумын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нэгтгэсэн тайланд хамрагдаж байгаа 6 байгууллагаас сумын нэгтгэсэн тайлан, ЗДТГ-т аудитын дүгнэлт гаргаж, ИТХ, эргэлтийн эмийн сан, орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сан нь түүвэрт хамрагдсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,483,842.7 мянган төгрөгөөр буюу 41,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	269,211.0	462,776.3	193,565.3
Авлага	323,384.2	326,584.4	3,200.2
Бараа материал	279,294.0	113,862.8	-165,431.2
Үндсэн хөрөнгө	5,053,024.6	2,537,847.6	-2,515,177.0
Нийт хөрөнгө	5,924,913.8	3,441,071.1	-2,483,842.7
Өр төлбөр	17,836.4	5,149.6	-12,686.8

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,907,077.4	3,435,921.6	-2,471,155.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,924,913.8	3,441,071.1	-2,483,842.7

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 462,766.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 193,565.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 270,674.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 133,507.6 мянган төгрөгөөр өссөн, мөн сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 86,994.2 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 326,584.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,200.2 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 4,857.2 мянган төгрөгийн авлагыг шилжүүлж, Сум хөгжүүлэх сан /Хоршоо хөгжүүлэх сан/-гийн 80,167.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж хассан бөгөөд ЗДТГ-т шилжих үлдэгдлээс санхүүжүүлж, ажил хүлээлцэх комисс хүлээж аваагүй ажлын 40,904.1 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн, эргэлтийн эмийн сангийн дутагдуулсан эмийн тооцоогоор үүсгэсэн 39,821.1 мянган төгрөгөөр авлага үүсгэсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 113,862.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 165,431.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 155,239.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн, эмийн эргэлтийн сангийн дутагдсан 41,159.6 мянган төгрөгийн бусад бараа материалыг авлагаар бүртгэж тайлагнасан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,537,847.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,515,177.0 мянган төгрөгөөр буурсан нь ОНХС-гийн санхүүжилтээр 59,829.4 мянган төгрөгийн багийн төвийн байрны засвар, ХХААГ-аас шинэ хөдөө төслийн хүрээнд 162,181.8 мянган төгрөгийн хадлан тэжээл бэлтгэх иж бүрдэл багц тоног төхөөрөмж, шилжих үлдэгдлээс 54,775.9 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн хөрөнгө оруулалтаар 12,000.0 мянган төгрөгөөр худаг, нийт 59,786.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авснаар ЗДТГ, ИТХ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн нөлөөлөлтэй байгаа бөгөөд, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,332,500.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, өмнөх жилийн нэгдсэн тайланд Аргалант илч ОНӨААТҮГ-ын 297,893.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө давхар нэгтгэгдсэнийг бууруулж тайлагнасан зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 5,149.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,686.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 2,904.9 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлж, эргэлтийн эмийн сангийн өглөг 4,994.0 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,435,921.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,471,155.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, өглөг, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 1,468,055.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 462,776.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 193,565.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	269,211.0	462,776.3	193,565.3
Төгрөг	269,211.0	462,776.3	193,565.3

/мянган төгрөгөөр/

Төрийн сангийн харилцах	261,451.8	455,231.6	193,779.8
Арилжааны банк дахь харилцах	7,759.2	7,544.7	-214.5
Дүн	269,211.0	462,776.3	193,565.3

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 455,231.6 мянган төгрөгийн 59,5 хувь буюу 270,674.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 2,2 хувь буюу 9,788.6 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 38,4 хувь буюу 174,768.8 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 7,534.5 мянган төгрөг, Аргалант илч ОНӨААТҮГ-ын үлдэгдэл 10.2 мянган төгрөг арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 193,779,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өмнөх оноос 133,507.6 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 86,994.2 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Арилжааны банкн дахь харилцахын оны эхний үлдэгдлээс Аргалант илч ОНӨААТҮГ-ын 157.6 мянган төгрөгийг НӨАТ-ын дутуу төлөлтөд шилжүүлж, эмийн эргэлтийн сангийн харилцахын үлдэгдэл 56.9 мянган төгрөгөөр буурч, нийтдээ 214.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт: Эмийн эргэлтийн сан арилжааны банк дахь харилцахын оны эхний үлдэгдэл 7,591.4 мянган төгрөг, эм, бараа борлуулалтын орлого 90,270.9 мянган төгрөг, урьд оны авлагаас 450.0 мянган төгрөг харилцах дансанд төвлөрүүлсэн. Эм, бараа материал худалдан авахад 90,310.3 мянган төгрөг, аудитын төлбөрт 108.0 мянган төгрөг, пос машины шимтгэлд 269.2 мянган төгрөг, бусад зардалд 90.4 мянган төгрөг нийт 90,777.9 мянган төгрөгийг зарлагын гүйлгээ хийж, харилцах дансны үлдэгдэл 7534.5 мянган төгрөг байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 195,239.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 70,784.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	7,148.1	45,533.9	38,385.8
Зээлийн хүүгийн авлага	1,525.8	0	-1,525.8
Байгууллагаас авах авлага	33,482.7	78,378.1	44,895.4
Хувь хүмүүсээс авах авлага	281,227.6	202,672.4	-78,555.2
Дүн	323,384.2	326,584.4	3,200.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 326,584.4 мянган төгрөгийн 62,1 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 24,0 хувийг байгууллагаас авах авлага, 13,9 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 99,8 хувь буюу 202,255.6 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 33,1 хувь буюу 25,925.5 мянган төгрөгийн авлага нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна.

Авлага дансны үлдэгдэл оны эхнээс 3,200.2 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих сумын Эрүүл мэндийн төвийн 4,857.2 мянган төгрөгийн авлагыг шилжүүлж, Сум хөгжүүлэх сан /Хоршоо хөгжүүлэх сан/-гийн 80,167.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж хассан бөгөөд ЗДТГ-т шилжих үлдэгдлээс санхүүжүүлж, ажил хүлээлцэх комисс хүлээж аваагүй ажлын 40,904.1 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн, эргэлтийн эмийн сангийн дутагдуулсан эмийн тооцоогоор үүсгэсэн 39,821.1 мянган төгрөгөөр авлага үүсгэсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь Өмнөх онд Тэмүүлэл ланд шафт ХХК-д спорт чийрэгжүүлэлтийн тоглоомын цогцолбор талбай ногоон байгууламж байгуулах 10,200.0 мянган төгрөгийн ажлыг хүлээж аваагүй байхад тайлант онд шилжих үлдэгдлээс дахин Тэмүүлэл ланд шафт ХХК-д бөхийн өргөөний дээвэр засварлах 7,000.0 мянган төгрөгийн ажлыг гэрээ байгуулалгүйгээр санхүүжилтийг бүрэн өгсөн, Билэгт зам ХХК-д хог хаягдлын цэг байгуулах түрж булах, төвийн гуу жалга дарж тэгшлэх 2 ажлын 30,000.0 мянган төгрөгийн ажлуудыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч, гүйцэтгэсэн ажлын тайлан, гэрээ дүгнэсэн баримтгүй, санхүүжилтийг бүрэн өгсөн, нийт 47,200.0 мянган төгрөгийн авлага үүссэн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3.904.1 мянган төгрөгийн тээвэр шатахууны авлага үүсгэж, оны эцэст хэмнэгдсэн зардлыг нөөцөлсөн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 113,862.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 165,431.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	84,508.8	24,365.4	-60,143.4
Тусгай зориулалттай материал	0	0	
Эм боох материал	84,508.8	24,365.4	-60,143.4
Хангамжийн материал	194,785.3	85,997.4	-108,787.9
Бичиг хэргийн материал	3,760.9	3,394.4	-366.5
Аж ахуйн материал	25,140.2	11,183.8	-13,956.4
Сэлбэг хэрэгсэл	7,824.0	2,984.0	-4,840.0
Түлш, шатах тослох материал	53.3	618.6	565.3
Барилгын засварын материал	5,272.3	2,472.3	-2,800.0
Хүнсний материал	7,939.5	0	-7,939.5
Бусад хангамжийн материал	144,795.0	65,344.3	-79,450.7
Мал амьтад	0	3,500.0	3,500.0
Дүн	279,294.0	113,862.8	-165,431.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 113,862.8 мянган төгрөгийн 76,3 хувийг ЗДТГ, 21,4 хувийг эмийн эргэлтийн сан, 2,3 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 165,431.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 66,082.0 мянган төгрөг, Цэцэрлэгийн 25,645.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 56,138.9 мянган төгрөг, Соёлын төвийн 7,372.8 мянган төгрөг, нийт 155,239.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг шилжүүлж, давхар бүртгэгдсэн Аргалант илч ОНӨААТҮГ-ын 13,396.1 мянган төгрөгийн бараа материалыг хасаж, эмийн эргэлтийн сангийн дутагдсан болон шүүхийн шатанд шийдвэрлүүлэх явцдаа байгаа 41,159.6 мянган төгрөгийн бусад бараа материалыг санхүү хяналт, дотоод аудитын албанаас “авлагаар бүртгэж тайлагнах” зөвлөмж хүргүүлсний дагуу эмийн үлдэгдлээс бууруулж шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Давхар бүртгэгдсэн Аргалант илч ОНӨААТҮГ-ын 13,396.1 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,537,847.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,515,177.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,325,053.7	1,884,658.9	-2,440,394.8
Барилга, байгууламж, орон сууц	3,749,675.0	1,457,423.3	-2,292,251.7
Авто-тээврийн хэрэгсэл	158,863.4	149,619.5	-9,243.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	231,534.9	196,538.2	-34,996.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	79,374.0	33,193.9	-46,180.1
Бусад үндсэн хөрөнгө	79,344.7	47,884.0	-31,460.8
Ном	26,261.6	0	-26,261.6
Биет бус хөрөнгө	727,970.9	653,188.7	-74,782.2
Программ хангамж	2,370.9	954.7	-1,416.2
Бусад биет бус хөрөнгө	725,600.0	652,234.0	-73,366.0
Дүн	5,053,024.6	2,537,847.6	-2,515,177.0

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,7 хувь буюу 2,530,163.4 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,3 хувь буюу 7,012.3 мянган төгрөгийг ИТХ, 0,03 хувь буюу 672.0 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,515,177.0 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 656,144.2 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 593,902.6 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 411,837.7 мянган төгрөгийн, Соёлын төвийн 670,616.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн мөн сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 01 тогтоолоор Аргалант илч ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг дуусгавар болгож, хөрөнгийг ЗДТГ-т бүртгэсэн байтал, өмнөх жилийн нэгдсэн тайланд үлдэгдэл цэвэр дүнгээр 297,893.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө давхар нэгтгэгдсэнийг бууруулж тайлагнасан тайлант онд бууруулж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт: Сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 01 тогтоолоор Аргалант илч ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг дуусгавар болгож, хөрөнгийг ЗДТГ-т бүртгэсэн байтал, өмнөх жилийн нэгдсэн тайланд 703,095.4 мянган төгрөгийн дансны үнэтэй, 405,202.3 мянган төгрөгийн хуримлагдсан элэгдэлтэй, үлдэгдэл цэвэр дүнгээр 297,893.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө давхар нэгтгэгдсэнийг тайлант онд бууруулж тайлагнасан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 5,149.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,686.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өр	0	0	0
Байгууллагад төлөх өр	17,836.4	5,149.6	-12,686.8
Дүн	17,836.4	5,149.6	-12,686.8

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 5,149.6 мянган төгрөг болж, 12,686.8 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн 2,904.9 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлж, эргэлтийн эмийн сангийн өглөг 4,994.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдлийн 97.0 хувь буюу 4,994.0 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 3.0 хувь буюу 155.6 мянган төгрөг нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын өглөг байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант оны өр төлбөр дансны жилийн эцсийн үлдэгдэл 5,149.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар бүрэн баримтжуулсан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,435,921.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,471,155.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,112,674.9	1,385,745.2	-1,726,929.7
Хуримтлагдсан үр дүн	1,522,735.9	1,907,704.6	384,968.7
Өмнөх үеийн үр дүн	1,146,320.1	3,375,760.3	2,229,440.2
Тайлант үеийн үр дүн	376,415.8	-1,468,055.7	-1,844,471.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,271,666.6	142,471.8	-1,129,194.8
Дүн	5,907,077.4	3,435,921.6	-2,471,155.8

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 2,471,155.8 мянган төгрөгөөр буурсан нь засгийн газрын оруулсан капитал 1,726,929.7 мянган төгрөгөөр буурч, хөрөнгийн дахин үнэлгээ 1,129,194.8 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 2,229,440.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 1,844,471.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Аргалант сумын төсвийн байгууллагуудын төсвийн төсөлд 1,923,784.0 мянган төгрөгийн орлого зардлын саналыг төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тусгай санхүүжилтийн байгууллагуудын төсвийг салбар тус бүрийн төсвийн ерөнхийлөн захирагчаас санхүүжүүлэхээр шийдвэр гарсны дагуу төлөвлөгөөг 963,386.2 мянган төгрөгөөр бууруулж, 960,397.8 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Аргалант сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 294,213.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 9,300.0 мянган төгрөг, татварын буцаалтыг 10,607.5 мянган төгрөг, нийт татварын орлогыг 292,905.5 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 960,397.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 288,176.5 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах нийт зарлагыг 942,070.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,729.0 мянган төгрөгөөр бууруулж, 288,176.5 мянган төгрөгөөр, нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 79,598.4 мянган төгрөгөөр бууруулж, 669,832.0 мянган төгрөгөөр, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварыг 61,270.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 131,270.7 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 140,968.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 942,070.1 мянган төгрөгөөр сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн “Аргалант сумын 2022 оны тодотгол батлах тухай” 01 дүгээр тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 25 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 288,176.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 398,287.9 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 94,807.1 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 24,808.8 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 131,270.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 942,070.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 47,429.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 894,640.8 мянган төгрөг буюу 95,0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 47,429.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	57,779.2	52,008.9	5,770.3	90.0%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	357,656.4	333,180.1	24,476.3	93.2%
3	ЕБС-үйлчилгээ	121,599.0	117,187.4	4,411.6	96.4%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	52,747.5	47,370.3	5,377.2	89.8%
5	Соёл урлагийн үйлчилгээ	49,261.1	48,186.0	1,075.1	97.8%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	30,788.2	29,482.6	1,305.6	95.8%
7	Хөрөнгийн зардал	272,238.7	267,225.4	5,013.3	98.2%
	Сумын дүн	942,070.1	894,640.8	47,429.3	95.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 29,733.8 мянган төгрөг, ИТХ 300.0 мянган төгрөг, нийт 30,033.8 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 7 хөтөлбөрийн 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	90%	57,779.2	52,008.9
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	93.2%	357,656.4	333,180.1
3	Соёл урлагийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	97.8%	49,261.1	48,186.0
4	Ерөнхий боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	96.4%	121,599.0	117,187.4
5	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	89.8%	52,747.5	47,370.3
6	ЭМТ-ийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	95.8%	30,788.2	29,482.6
7	Хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр арга хэмжээ	2022 он	хөрөнгийн чанар байдал сайжирна	86.7%	272,238.7	236,021.8

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд Орон нутгаас хийгдэх хөрөнгийн зардлын 21,352.1 мянган төгрөгийн мал угаалгын ванн худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлээгүй байна. Энэ нь малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө биелээгүй бөгөөд, ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүйгээс болсон байна. Хөшөөт багийн камержуулалтын ажил дуусаагүй ажлыг хүлээж аваагүйгээс санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/12 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 942,070.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,131.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,598.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн жилийн хүрээнд 6 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 29,190.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 3,607.1 мянган төгрөг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 174 мэдээллээс 20 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийн хугацаа болоогүй төлөвт байна. Тендер шалгаруулсан, худалдан авах ажиллагаатай холбоотой 132,327.4 мянган төгрөгийн 6 мэдээлэл, 300.0 мянган төгрөгийн 4 шийдвэр байршуулсан бөгөөд нэгдсэн тайланд хамрагдагч байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотойгоор ЗДТГ-т албан шаардлага, ИТХ, орон нутгийн хөгжлийн сан, эмийн эргэлтийн сан 3 байгууллагад зөвлөмж өгөгдсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.3-д харуулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөний хэрэгжилтийг ирүүлсэн мэдээлэл тодорхойгүй, шилэн дансанд байршуулаагүй байна. Харин fas.audit.mn системд бүрэн хэрэгжсэнээр шивсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	54,203.8	2	54,203.8	100
Зөвлөмж	2	44,367.4	2	44,367.4	100
Нийт дүн	4	98,571.2	4	98,571.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудлаар Аргалант илч ОНӨААТҮГ-аас шилжиж ирсэн хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалтын асуудлыг тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нэгтгэсэн тайланд харьяа 4 байгууллагын тайланд мэдээллийг буруу тусган илэрхийлсэн 168,648.3 мянган төгрөгийн 6 алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулга хийгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн 6.1-д харуулав.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар Аргалант сумын нэгтгэсэн тайлангаар 9,050.5 мянган төгрөгийн 2 зөрчил, ИТХ-ын 280.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

1.Аймгийн Засаг даргын 03 албан тоотыг үндэслэн 3,154.5 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 “Урамшуулал гэдэгт ...нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал хамаарахгүй” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

2.Нэмэлт санхүүжилтийн дансанд он дамнан зарцуулаагүй үлдэгдэл 5.896.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх” зарчимтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “ангилал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

3.ИТХ-н даргын 2022 оны 12 дугаар сарын 25-ны 21 дүгээр захирамжаар “Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 онд төсвийн зөрчилгүй, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, шилэн дансаа тогтмол хөтөлсөн, жилийн ажлын гүйцэтгэл 94.8 үнэлгээ авсан тул” нягтлан бодогчид 40 хувийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”

зарчимтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

Төлбөрийн акт тогтоогдсон зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

5.2 Албан шаардлага

Аудитаар харьяа байгууллагуудаас Аргалант сумын ЗДТГ-ын 47,200.0 мянган төгрөгийн 1 зөрчил, эмийн эргэлтийн сангийн 65,887.7 мянган төгрөгийн 1 зөрчил, нийт 113,087.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Албан шаардлага өгөгдсөн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд төсвийн орлогыг нийт дүнгээр 173 хувиар биелүүлсэн боловч, улсад төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогыг 12,509.8 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлогыг 22,828.4 мянган төгрөгөөр нийт 35,338.2 мянган төгрөгийн 6 нэр төрлийн орлогыг бүрдүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүх шатны төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэх.

2. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ИТХ нь тайлант онд цахим баримтаар баримтжуулах 8 байгууллага, иргэдээс 1,784.6 мянган төгрөгийн худалдан авалтыг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлэх" гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүх шатны төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэх.

Аудитаар Аргалант сумын нэгтгэсэн тайлангийн 35,338.2 мянган төгрөгийн 1 зөрчил, ЗДТГ-ын 2 зөрчил, ИТХ-ын 1,784.6 мянган төгрөгийн 1 зөрчил, нийт 37,122.8 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгуулл агын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулса н		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөм ж	
							Залруулсан		Залруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	128,058.7			2	128,058.7	2	128,058.7				
ИТХ	2	26,263.1			2	26,263.1	2	26,263.1				
ОНХС	1	7,500.0			1	7,500.0	1	7,500.0				
СХС	1	6,826.4			1	6,826.4	1	6,826.4				
Дүн	6	168,648.2	0	0	6	168,648.2	6	168,648.2				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	3	44,388.8	2	9,050.5			1	35,338.2				
ЗДТГ	6	53,388.9	3	6,188.9	1	47,200.0	2	0				
ИТХ	2	2,065.0	1	280.4			1	1,784.6				
ЭЭС	1	65,887.7			1	65,887.7						
Дүн	12	165,730.4	6	15,519.8	2	113,087.7	4	37,122.8	0	0	0	0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	0			1	0		
ИТХ	1	0					1	0
ЭЭС	1	24,850.3					1	24,850.3
ОНХС	1	119,616.6					1	119,616.6
Дүн	4	144,466.9			1	0	3	144,466.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	4	144,466.9			1	0	3	144,466.9

